



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 28 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 7-р сарын 3-аас 7-р сарын 9-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 17 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Европын Холбооны 7-р сарын 7-ны “Европын Эдийн Засгийн Төсөөлөл: 2020 оны зун” тайланд нийтэлснээр **Евро бүсийн эдийн засаг 2020 онд 8.7 хувиар агшиж, 2021 онд 6.1 хувиар өсөх**, Европын холбооны¹ эдийн засаг энэ онд 8.3 хувиар агшиж, ирэх онд 5.8 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Энэ нь өмнөх улирлын төсөөллөөс муудсан үзүүлэлт юм². Цаашид Ковид-19-ийн тархалт, хөл хорио хэр удаан үргэлжлэхээс хамааран төсөөлөл муудах магадлалтай бөгөөд ийм эрсдэл өндөр байгааг онцлов.
- АНУ-ын Конгрессын Судалгааны төвөөс “Ковид-19-ийн дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө” судалгааны тайланг 7-р сарын 2-нд нийтэллээ. Уг тайланд Ковид-19-ийн хоёр дахь давалгаа үүсэхгүй тохиолдолд **дэлхийн эдийн засаг энэ онд 3-6 хүртэлх хувиар агших** төлөвтэй гэжээ. Эдийн засгийн уналт хэр гүн байхаас шалтгаалан дэлхийн нийтийн худалдаа **13-32 хувиар агшиж**, гадаад худалдаанаас өндөр хамааралтай хөгжиж буй орнуудад хүнд цохилт болохыг онцлов.
- Bank of America-ийн дэлхийн эдийн засгийн 7-р сарын 2-ны мэдээлэлд **дэлхийн эдийн засаг энэ онд 4.1 хувиар агших**, ирэх жил 5.8 хувиар сэргэхээр төсөөлж байгааг дурджээ. Ковид-19-ийн тархалт нэмэгдэж, шинээр хөл хорио, “Нийгмийн хязгаарлалт” баримтлах шаардлагууд тавигдаж байгаа нь **W хэлбэрийн эдийн засгийн хямралыг нөхцөлдүүлж болзошгүй** гэж тус банк үзэж байна.
- **ХБНГУ-ын аж үйлдвэрлэл энэ оны 5-р сард өмнөх сараас 7.8 хувиар өсч, сэргэлт ажиглагдаж эхэллээ.** Энэхүү өсөлтийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлдвэрлэл голлон бүрдүүлсэн байна. Хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэл өсөлттэй байгаа бол завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурсан байна. Жилийн дүнгээр аж үйлдвэрлэл 4-р сард 25 хувиар агшаад байсан бол 5-р сард -19.3 хувь болж агшилт саарчээ.

¹ Евро бүс гэдэг нь еврог мөнгөн тэмдэгтээр ашигладаг 19 орныг нэрлэдэг бол Европын холбоо нь Маастрихийн гэрээнд нэгдсэн 28 улсыг хэлдэг.

² Уг байгууллага 2020 оны хаврын төсөөлөлд Евро бүсийн эдийн засаг 7.7 хувиар, Европын холбооны эдийн засаг 7.4 хувиар өсөхөөр төсөөлж байсан.

- АНУ-д хөл хориог сулруулж, хөдөлмөрийн захын сэргэлт үргэлжилж байна. Чөлөөт цаг, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, мэргэжлийн болон бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээний секторуудад ажил эрхлэлт нэмэгджээ. Түүнчлэн, ажилгүйдлийн түвшин 5-р сард 13.3 хувь байсан бол 6-р сард 11.1 хувь болж буурлаа. Ажил эрхлэлтийн оролцооны түвшин 5-р сард 60.8 хувиас 6-р сард 61.5 хувь болж нэмэгджээ. Цагийн хөлс 6-р сард өмнөх сараас 1.2 хувиар буурсан бол жилийн дундаж цалин 5-р сард 6.7 хувь буураад 6-р сард 5.0 хувь болж бууралт нь багасчээ.

Эх сурвалж:

1. European Commission, [Summer 2020 Economic Forecast: An even deeper recession with wider divergences](#)
2. Congressional Research Service, [Global Economic Effects of COVID-19](#)
3. Bank of America, [Global Macro Snapshot: Can't shake that cautious feeling](#)
4. Focus Economy, [Germany: Industrial output rebounds in May](#)
5. Focus Economy, [United States: Labor market continues to recover in June](#)
6. Financial times, [US weekly jobless claims of 1.3m show gradual improvement](#)

2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД


- Азийн нэгдсэн PMI индекс 6-р сард өмнөх сараас нэмэгдэв. Үүнд Австрали, БНЭУ, Японы үйлчилгээний PMI индекс 5-р сард 30-аас доогуур түвшинд хадгалагдсан бол 6-р сард 26.2, 21.1, 17.6-ээр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.
- БНХАУ-ын Шанси, Шаанси, ӨМӨЗО-ны нүүрсний нийт үйлдвэрлэл оны эхний 5 сард 226 сая тонн хүрч БНХАУ-ын нийт үйлдвэрлэлийн 70.8 хувийг бүрдүүлэв. Түүнчлэн Шанси, Шаанси мужийн үйлдвэрлэл оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 2.7 хувь, 23.6 хувиар тус тус нэмэгдсэн бол Өвөр Монголын үйлдвэрлэл 3.5 хувиар буурав. Зөвхөн 5-р сарыг авч үзвэл Өвөр Монголын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурсан бол Шанси, Шаанси мужуудын үйлдвэрлэл 0.7 хувь, 22.1 хувиар тус тус нэмэгджээ.
- Нүүрсний импортын хориг чангарсан нөлөөгөөр 5-р сард БНХАУ-ын нүүрсний нийт импорт 22.06 сая тоннд

хүрч өмнөх оны мөн үеэс 19.7 хувиар буурлаа. Харин оны эхний 5 сард нийт импорт 149 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 16.9 нэмэгдэв. БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний импорт 5-р сард 17.3 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 20 хувиар буурав. БНХАУ-ын Индонезоос импортолсон эрчим хүчний нүүрсний хэмжээ өмнөх оны мөн үеэс 15.8 хувиар буурч 5-р сард 11.1 сая тоннд хүрсэн, Австралиас импортолсон эрчим хүчний нүүрсний хэмжээ 3.23 сая тоннд, ОХУ-аас импортолсон нүүрсний хэмжээ 2.02 сая тоннд, Монгол Улсаас импортолсон нүүрсний хэмжээ 0.13 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 16.5, 39.2, 13.3 хувиар тус тус буурав.

- БНХАУ-ын коксжих нүүрсний нийт импорт 5-р сард 4.8 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 19.1 хувиар буурав. БНХАУ-ын Австралиас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 5-р сард 2.07 сая тоннд, Канадаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 0.52 сая тоннд хүрч 49.6 хувь, 44.5 хувиар тус тус

нэмэгдсэн бол Монгол Улсаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 1.71 сая тоннд, ОХУ-аас импортолсон нүүрсний хэмжээ 0.37 сая тонн болж 51.6 хувь, 37.1 хувиар тус тус буурав.

Зураг 1. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт, 5



- **БНХАУ-ын автомашины үйлдвэрлэл**
5-р сард 2.15 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 19 хувиар, өмнөх сараас 2.5 хувиар тус тус нэмэгдэв. Үүний зэрэгцээ автомашины борлуулалт 5-р сард 2.19 саяд хүрч өмнөх сараас 6 хувь, өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар тус тус нэмэгдлээ. Харин автомашины үйлдвэрлэл оны эхний 5 сард 7.96 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар буурсан байна.

Эх сурвалж:

1. Bloomberg, Asia Insight: Service PMIs Play Catch-Up, Face Virus ceiling
2. Bloomberg, China React: PMIs get export lift, weather Beijing Outbreak
3. Bloomberg, China Commodities Today
4. Sxcoal, China Coking coal market monthly: June
5. Sxcoal, China Thermal coal monthly: June,

3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газар 2020 оны 7 дугаар сарын 10-ны Баасан гарагт хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 7 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгав

Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгалаа.

ДЭМБ-ын мэдээллээр 2020 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар коронавируст халдварын цар тахал дэлхийн 216 улс, нутаг дэвсгэрийг хамран нийт 12 сая хүн халдвар авч, 550 мянга орчим хүн нас бараад байна. Иймд дэлхийн 40 гаруй улс онц байдал зарлаж, 22 улс хөл хорио тогтоон, 109 улс хилээ хэсэгчлэн болон бүрэн хааж, хөл хорио тогтоох, хилээ хаах хугацаагаа сунгаж байна.

Монгол Улсын хувьд уг өвчний 227 тохиолдол зөөвөрлөгдөн орж ирж бүртгэгдсэнээс 195 нь эмчлэгдэж, 32 хүн эмчлүүлж, 3077 хүн тусгаарлалтад байна. Батлагдсан тохиолдлын 84 хувь нь ОХУ-д сурч, амьдарч байсан иргэдээс илэрчээ. БНХАУ-д тархалт буурахгүй, хоёр дахь үеийн давалгаа эхэлснийг зарлаад байгаа юм. Иймд хөрш орнуудын нөхцөл байдал болон гадаад дахь иргэдээ татан авч байгаатай холбогдуулан дээрхи эрсдэлүүдийг тооцон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгахаар шийдвэрлэлээ.

Эх сурвалж:

Монгол Улсын Засгийн газар, [Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 7 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгав](#)

4 МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

| Бодит гүйцэтгэл | | | | | | | Товч тайлбар |
|---------------------------|-------------------------------|----------|--------|---------|--------------|--------|--|
| | Үнэ (-1 day) 2020/07/08 | Өөрчлөлт | | | | | |
| | | daily | weekly | monthly | year to date | YoY | |
| Зэс | 6230.2 | 1.1% | 3.8% | 9.5% | 2.2% | 8.5% | БНХАУ-ын үйлдвэрлэлийн салбарын идэвхжил хадгалагдсан, улс орнуудын хөл хорио суларч эхэлсэн, эрэлт нэмэгдсэн нь үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөллөө. |
| Коксжих нүүрс | 116.3 | - | - | - | - | -37.1% | Худалдааны маргаан, Ковид-19-ийн нөлөөгөөр эрэлт нэмж буурах төлөв болон БНХАУ-ын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх нөлөөгөөр үнэ бага түвшинд хадгалагдаж байна. |
| Төмрийн хүдэр | 101.6 | 0.0% | 3.2% | 0.2% | 9.8% | -13.6% | БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн сэргэлт хадгалагдсан, боомтууд дээрх нөөц нэмэгдэж буй, хөл хорионы улмаас Бразил Улсын нийлүүлэлт буурахаар байгаа хэдий ч энэ нь богино хугацаанд шийдвэрлэгдэх хүлээлтийн нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногоос нэмэгдэв. |
| Алт | 1808.89 | -0.3% | 1.6% | 5.1% | 18.0% | 27.1% | Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр байгаа тул аюулгүй, найдвартай хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна. |
| Газрын тос (Брент) | 43.29 | -2.2% | -1.8% | 2.8% | -36.1% | -34.0% | ОПЕК-ийн нэгдэл олборлолтоо бууруулсан, АНУ дахь нөөц өмнөх долоо хоногоос нэмэгдсэн, олон улсын эрчим хүчний агентлаг газрын тосны эрэлтийг 5-р сарын төсөөллөөс нэмэгдүүлсэн хэдий ч цар тахлын тархалт огцом нэмэгдсэн нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногоос буурав. |